

## ИЛТГЭХ ХУУДАС



*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод,  
хяналт шалгалт хийсэн тайлан  
/1 дүгээр улирал/*

2024 он

АУДИТ ХИЙГДСЭН ГАЗАР:

САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

АУДИТЫН ТӨРӨЛ:

ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТӨД ДОТООД  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ

АУДИТЫН ХУГАЦАА:

/2024.04.15-2024.04.22/

ТАНИЛЦСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




Н.БУДБАЯР

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА:

Н.МӨНХСҮРЭН

АУДИТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТОР



Л.УУГАНЦЭЦЭГ

## ГАРЧИГ

Нэг. Ерөнхий зүйл .....	4
1.1. Дотоод аудитын зорилго, үндэслэл: .....	4
1.2. Дотоод аудитын бүрэлдэхүүн, ажилласан хугацаа: .....	4
1.3. Дотоод аудитад хамрагдсан асуудлууд: .....	4
1.4. Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл: .....	5
Хоёр. Бодит байдал .....	5
2.1. Үндсэн мэдээлэл .....	5
2.2. Илэрсэн асуудлууд: .....	5
Гурав. Дүгнэлт .....	6
Дөрөв. Зөвлөмж .....	7
Тав. Бусад .....	7

## **Нэг. Ерөнхий зүйл**

### **1.1. Дотоод аудитын зорилго, үндэслэл:**

“Шилэн дансны тухай хууль”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр батлагдсан А/31, А/50 дугаар тушаалыг тус тус үндэслэн тус компанийн 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлуудыг засаж сайжруулан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар санал дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулав.

Дотоод аудитад дараахь хууль, дүрэм, журам, эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон ажиллав. Үүнд:

“Төрийн хяналт шалгалтын тухай” хууль,

“Шилэн дансны тухай хууль”,

“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль,

“Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм”,

“Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”,

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт, үнэлгээ хийх нийтлэг журам”,

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дүрэм,

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2023 оны 3 дугаар сард батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”,

“Тавантолгой төмөр зам ХХК-ийн хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тус тус үндэслэн дотоод аудит, хяналт шалгалтыг явуулав.

### **1.2. Дотоод аудитын бүрэлдэхүүн, ажилласан хугацаа:**

“Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын алба”-ны аудитор Л.Ууганцэцэг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг дуусталх хугацаанд “Юнион бьюлдинг” дэх компанийн төв оффист ажиллав.

### **1.3. Дотоод аудитад хамрагдсан асуудлууд:**

Мэдээллийн ил тод, байдал, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд “Тавантолгой төмөр зам” ХХК-иас 2024 оны 1 дүгээр улиралын байдлаар байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдал, газар, хэлтэс, нэгжүүдээс тухайн хуулийн мэдээллийг байршуулж олон нийтэд тайлагнасан талаар Үүнд:

Нэг. Төсөв, гүйцэтгэл,

Хоёр. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт,

Гурав. Бусад гэсэн агуулгын хүрээнд мэдээлэл үнэн зөв хугацаандаа байршуулсан эсэхт хяналт хийв.



#### 1.4. Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт, үнэлгээ хийх нийтлэг журам”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсаар жил, хагас жил, сар бүр, тухай бүр гэсэн хугацааны давтамжтайгаар 3 зорилтын хүрээнд төсөв, гүйцэтгэлийн 13, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 6, бусад 8 нийт 27 төрлийн 45 мэдээллээс 1 дүгээр улирлын байдлаар цахим хуудсанд байршуулсан байдалд хяналт тавьж, ажиллалаа.

#### Хоёр.Бодит байдал

##### 2.1. Үндсэн мэдээлэл

Тус байгууллага нь “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс 2023 оны 07 дугаар сараас эхлэн нийтэд нээлттэй мэдээллэх, хуульд ил тод, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар тус компанийн нийтэлсэн мэдээлэлд 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр үнэлгээ хийхэд 3 зорилтын 27 төрлийн 45 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас **100** хувь байршуулсан-**42**, **30** хувь буюу мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан **3** мэдээлэл байсан.

Нийт хэрэгжилт **94** хувьтай бөгөөд **Тодорхой үр дүнд хүрсэн**” гэсэн үнэлгээтэй байна.

##### 2.2 Илэрсэн асуудлууд:

###### Илэрсэн зөрчлүүд:

Илрүүлсэн ажилтны нэр: Л.Ууганцэцэг

Аудит хийгдсэн ажил: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт /2024 оны 1 улирал/

Бодит нөхцөл байдал:

Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

#### Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /2024 оны 1 дүгээр улирлын байдлаар/

Хүснэгт 1.

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Байршуулсан мэдээллийн төрөл	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Мэдээлэл оруулаагүй	Хэрэгжилтийн дундаж хувь
					100	90	70	50	30		
1.	Төсөв, гүйцэтгэл	13	12	12	-	-	-	1	-	-	94,6%
2.	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	11	9	9	-	-	-	2	-	-	87,2%
3.	Бусад	21	21	21	-	-	-	-	-	-	100%
<b>Дүн</b>		<b>45</b>	<b>42</b>	<b>42</b>	-	-	-	<b>3</b>	-	-	<b>94%</b>